



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТНОРОВ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 4/150

Батноров сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын (Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам)-ын 3.5.5 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 16 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Батноров сумын нутаг дэвсгэрт аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөө болон нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд 10.000.000 (Арван сая) төгрөгийг олгосугай.

2.Арга хэмжээнд зарцуулах 10.000.000 (Арван сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас санхүүжүүлэхийг санхүү албаны нягтлан бодогч (Б.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Б.Өсөхбаяр)-д даалгасугай.



Б.ЖАВХЛАНБАЯР

230423357